

ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ: ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа

Судалгааны код: СТ-18/202

АГУУЛГА

1. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн онолын үзэл баримтлал, үндэслэл (эрх зүйн философийн үүднээс)
1.1. Эрх зүйн философи дахь “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн үндэс
1.2. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээ
1.3. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт

2. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага (харьцуулсан судалгаа):
2.1. ХБНГУ
2.2. ОХУ
2.3. АНУ

3. Эрх зүйн онол дахь “хувь хүн”, “бие хүн” гэх ойлголтуудын тодорхойлолт, ялгаа

Ашигласан материал

Улаанбаатар
2018 он

Судалгааны хураангуй

Судалгааны 1-р хэсэгт, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн онолын үндсийг эрх зүйн философийн үүднээс товч авч үзсэн бөгөөд тус эрхийн үндэсний болон олон улсын эрх зүйн тодорхойлолт, эрхийн бүрэлдэхүүн /хүрээ, хязгаар/, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт зэрэг ойлголтуудыг авч үзэв.

Судалгааны 2-р хэсэгт, ХБНГУ, АНУ, ОХУ зэрэг улс орнуудын Үндсэн хуульд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хэрхэн тодорхойлсон, түүний хүрээ хязгаар, ямар хуулиудаар зохицуулдаг зэрэг асуудлыг тусгав.

Судалгааны 3-р хэсэгт, эрх зүйн онол дахь “хувь хүн”, “бие хүн”-ий тухай ойлголт, тэдгээрийн ялгаатай талыг авч үзэв.

Судалгааны үр дүнгийн тойм

“Халдашгүй, чөлөөтэй байх эрх” нь онолын хувьд хүний салгаж үл болох **үндсэн эрх** гэх ойлголтод хамаарах эрх зүйн философийн үндсэн ухагдахуун бөгөөд **жам ёсны эрхийн онолд** хамаарна. “Халдашгүй эрх” нь “*inviolability*”, болон “*immunity*”, “*privacy*”, “*inviolability of individual life*”, “*inviolability of home*” зэрэг хууль зүйн нэр томьёо, ойлголтуудаар илэрхийлэгддэг өргөн хүрээтэй ойлголт бөгөөд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт”-д тунхагласан байдаг.

Хүн халдашгүй, чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх бөгөөд энэхүү эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулдаг, хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй **туйлын эрх** юм. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх” нь:

- (1) Эрх чөлөөтэй байх (*чөлөөтэй байх халдашгүй эрх ч гэдэг*);
- (2) Бие, махбодийн халдашгүй эрх;
- (3) Орон байрны халдашгүй байдал;
- (4) Нууцын халдашгүй эрх;
- (5) Нэр төрийн халдашгүй байдал;
- (6) Өмчийн халдашгүй байдал гэсэн 6 төрлийн эрхээс бүрдэнэ.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг бүрдүүлж буй эдгээр эрх нь тус бүрдээ өөр өөрийн гэсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд дэлгэрэнгүйг судалгааны тайлангаас үзнэ үү.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн зарим хэсгийг Үндсэн хууль болон үндэсний холбогдох хууль тогтоомжоор заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно. Гэвч ямар ч нөхцөлд хязгаарлаж болохгүй эрх байдаг байна.